



УЛААНБААТАР ХОТЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 29 өдөр

Дугаар 0104

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл  
ахуйн журам батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.6, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.9.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журмыг нийт албан хаагчдад танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргжилтэн /Н.Батсүх/-д үүрэг болгосугай.
3. Дээрх журмыг батлан гаргасан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг бүх албан хаагчдад үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАН-ОЧИР

Улаанбаатар хотын Шуурхай удирдлага,  
зохицуулалтын төвийн даргын 2016 оны 02  
дугаар сарын 29 ны өдрийн 104 дугаар  
тушаалын хавсралт



## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЖУРАМ

### Нэг. Журмын зорилго

1.1 Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төвийн /цаашид "Төв" гэх/ албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг сайжруулах, хангах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

### Хоёр. Ерөнхий зүйл

2.1 Төвийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй техник технологи, тоног төхөөрөмжтэй харьцах явцад хүний эрүүл мэндэд хохирол учруулж болох аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү журмыг дагаж мөрдөнө.

### Гурав. Нийтлэг шаардлага

3.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний санхүүжилтийг "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль"-ийн 26 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэж, хэрэгжүүлнэ.

3.2 "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль"-ийн 27.2 дугаар зүйлд заасны дагуу төвийн дарга нь үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, ажлын байрны эрсдэлийн түвшин, албан хаагчдын тоог харгалзан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан, зөвлөл ажиллуулна.

3.3 "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль"-ийн 28.2.1 дүгээр зүйлд заасны дагуу төвийн дарга нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл байгуулах, ажилтныг ажилд томилох, ажлаас чөлөөлөх эрхтэй.

3.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан нь энэхүү журмын 3.1-д заасны дагуу төсвийн төсөлд санал өгнө.

3.5 Төв нь нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт жилд 1-2 удаа заавал хамруулсан байна.

3.6 Хөдөлмөрлөх явцад албан хаагчийн хөдөлмөрийн чадвар, эрүүл мэндэд нь нөлөөлөх ажлын байрны нөхцөлийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгоно.

3.7 Төв нь нийт албан хаагчдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон галын аюулгүй байдлыг хангах сургалтанд хамруулсан байна.

3.8 Амархан шатах, тэсэрч дэлбэрэх материалыг ажлын байранд байлгах, ил гал гаргахыг хориглоно.

### Дөрөв. Ажлын байрны эрүүл ахуйн шаардлага

4.1 Төвийн ажлын байрны нөхцөлийг эрх бүхий байгууллагаар тогтоолгосны үндсэн дээр ажлын байрны нөхцөл аюулгүй байдлыг стандартын шаардлагад нийцүүлэн хангах арга хэмжээг хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тусган хэрэгжүүлнэ.

4.2 Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах ажлын байрны орчны эрүүл ахуй нь /агаарын температур, чийгшил, агаарын хөдөлгөөний хурд, гэрэлтүүлэг, хорт туяа, тоос, химийн бодисын тархалт, ууршилт MNS 4990:2000, MNS 4996:2000, MNS 4990:2000/ стандартад заасан хэмжээнд байна.

4.3 Албан хаагчдын ахуйн байр нь /түр амрах, хувцас солих, бие засах, г.м/ тусгайлан төхөөрөмжилсөн, ариун цэвэр, эрүүл ахуйн норм стандартыг хангасан байна. Зөвшөөрөгдсөнөөс бусад газарт хооллох буюу тамхи татахыг хориглоно.

4.4 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа албан хаагчид мэргэжлийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу хор саармагжуулах бүтээгдэхүүн олгоно.

4.5 Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх эмийн сантай байна.

#### **Тав. Ажлын багаж, тоног төхөөрөмжинд тавигдах шаардлага**

5.1 Ажлын багаж, хэрэгсэл нь MNS IEC 335-2-2000 стандартын шаардлага хангасан /шамралтгүй, зориулалтын шаантагтай, бариул болон иш нь барихад тохиромжтой, цахилгааны хүчдэлээс хамгаалагдсан г.м/ байна.

5.2 Ажлын багаж нь зориулалтын тавиур, өлгүүр, шүүгээ болон үүрч явах цүнх, савтай байна.

5.3 Тоног төхөөрөмж, машин механизм нь техникийн бүрэн бүтэн байдал, ажиллах шаардлагыг хангасан байна.

5.4 Тоног төхөөрөмжийн онцлогт тохирсон стандартын шаардлага хангасан аянга зайлуулагч ашиглах, хамгаалалтын газардуулгад холбогдсоны дараа ажлыг эхлүүлнэ.

5.5 Машин механизм, тоног төхөөрөмж, өргөх, зөөх, тээвэрлэх механизм, даралтат сав, шугам хоолойд тавигдах шаардлагууд нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 9, 10, 11 дүгээр зүйлд заасан тавигдах нөхцөлд нийцсэн байна.

#### **Зургаа. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл**

6.1 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл нь стандартын шаардлага хангасан байна.

6.2 Баталгаажуулсан техникийн бичиг баримтгүй, ашиглалтын хугацаа дууссан, гэмтэлтэй, иж бүрдэлгүй хамгаалах хэрэгслийг ашиглахыг хатуу хориглоно.

6.3 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн талаар ажилтан нэг бүр өөрийн ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг шалгаж энэхүү журмын 6.1, 6.2-ыг мөрдлөг болгон ажиллана.

6.4 Тусгай хэрэгслийн ажлын хувцсыг албан үүргээ гүйцэтгэхдээ албан хаагч заавал хэрэглэнэ.

6.5 Тухайн албан хаагчийн хувцас, багаж хэрэгсэл бүрэн бус, шаардлага хангаагүй нөхцөлд ажил гүйцэтгэхийг хатуу хориглоно.

6.6 Стандартын шаардлага хангасан ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг худалдан авахдаа холбогдох албан хаагчдаас санал авсан байна.

6.7 Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг ажилтан дур мэдэн зарж борлуулахыг хориглоно. Зарж борлуулсан тохиолдолд үнийг 3 дахин нэмэгдүүлж төлүүлнэ.

### **Долоо. Засвар үйлчилгээний үеийн аюулгүй ажиллагааны шаардлага**

7.1 Засварын ажил эхлэхийн өмнө ажилтан ажлын багаж хэрэгсэл бүрэн гүйцэд байгаа эсэх, хамгаалах хэрэгсэл, бүс, хувцасны бүрэн бүтэн байдалд хяналт тавьж зөрчилтэй зүйлийг арилгана.

7.2 Ажлын байрны нөхцөл, зам талбай, гэрэлтүүлэг, тавиур, шат, вандан, гүүр гарц, ажил үүрэг гүйцэтгэх газрын өндөр нам зэргийг урьдчилан шалгаж аюулгүй ажиллах нөхцөл байдлыг тогтоосны дараагаар ажил эхэлнэ.

7.3 1,8 м-ээс дээш өндөрт болон гүний худагт орж ажиллах үед хамгаалах бүс, шат, олс, дуулга малгай, зөөврийн гэрэл зэргийг заавал хэрэглэх шаардлагатай.

7.4 Цахилгаан болон гар багаж хэрэгслээр ажиллахдаа түүний зориулалтын хаалт хамгаалалтыг авах, зориулалтын хамгаалалтгүй багаж хэрэгслээр ажиллах, өөр зүйлээр орлуулан хэрэглэхийг хориглоно.

7.5 Өндөрт ажиллахаасаа өмнө цахилгааны эх үүсвэрийг шалгах ба шаардлагатай тохиолдолд цахилгаан хүчдэлийг салгаж, ажлыг эхлүүлнэ.

7.6 Өндөрт ажиллах үед 2-оос доошгүй албан хаагч ажиллах ба багаж хэрэгсэл, эд материалыг сагсанд хийж олсоор зөөвөрлөнө.

7.7 Өргөгч машин механизмын сагсанд ажиллах албан хаагч нь эмчийн үзлэгт хамрагдан өндөрт ажиллах зөвшөөрөл авсан байх ба каск өмсөж, хамгаалах бүсийг сагсны металл хийц эсвэл бариулаас оосорлосон байна.

7.8 Өргөгч машин механизмыг ашиглах үед салхины хурд 10 м-ийн өндөрт 10 м/с-ээс хэтрэх, аадар бороо, цас орох эсвэл манан татах зэргээр үзэгдэх орчин хязгаарлагдах, түүнчлэн орчны хэм заасан хэмжээнээс буурах тохиолдолд өргөгчийн үйл ажиллагааг зогсооно.

### **Найм. Албан хаагчдын эрх, үүрэг**

8.1 Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа албан хаагч дараах нийтлэг эрхтэй байна:

8.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах;

8.1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамрагдах;

8.1.4 Ажлын байрны нөхцөл, эрүүл мэндэд учирч болох эрсдэл, түүнчлэн үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн талаар бодит мэдээлэл авах;

8.1.5 Ажил, үүргээ биелүүлэх явцад хөдөлмөрийн аюулгүй байдлын журам зөрчигдсөн болон амь нас, эрүүл мэндэд нь сөрөг, аюултай нөхцөл бий болсон тохиолдолд ажлаа зогсоож, энэ талаар ажил олгогчид мэдэгдэх;

8.1.6 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хэлэлцэхэд өөрөө болон төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох.

8.1.7 Хөдөлмөр хамгааллын аюулгүй хангагдаагүй тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэхээс татгалзах.

8.2 Ажил, хөдөлмөр эрхэлж байгаа албан хаагч дараах нийтлэг үүрэгтэй байна.Үүнд:

8.2.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтан нь аюулгүй ажиллагааны зааварчилгааг заавал өгч, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дэвтэрт гарын үсэг зуруулах;

8.2.2 Инженер техникийн ажилтан нь ажил гүйцэтгэх талбай дээр гарахаас өмнө өгөгдсөн зааварчилгааны дагуу бүх бэлтгэл ажлыг хангасны дараа ажлыг эхлүүлэх;

8.2.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт, дүрэм, технологийн горимыг чанд мөрдөх;

8.2.4 Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд нь сөрөг нөлөөлөх нөхцөл бий болсон тохиолдолд аюулгүй байдлын дүрэм, журамд заасны дагуу шуурхай арга хэмжээ авах;

8.2.5 Эрүүл мэндээ хамгаалах, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд орох;

8.2.5 Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зориулалтын дагуу хэрэглэх;

8.2.6 Ажил, үүргээ осол эндэгдэлгүй гүйцэтгэх арга барил, мэргэжлийн ур чадвар эзэмших, осол гэмтэл, хурц хордлогоос сэргийлэх, болзошгүй аюул, ослын үед анхан шатны тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байх;

8.2.7 Өөрийгөө болон бусдыг аюул, эрсдэлд учруулахгүй байх;

8.2.8 Албан хаагч бүр галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал гарсан үед гал унтраах багаж хэрэгсэлтэй ажиллах, гал унтраах чадвар, мэдлэгийг эзэмшсэн байх;

8.2.9 Ажил олгогчийн зүгээс хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг биелүүлж ажиллах.

## **Ес. Хүлээлгэх хариуцлага**

9.1 Байгууллага удирдлагын зүгээс хувцас, хэрэгсэл шаардлага хангаагүй нөхцөлд ажил гүйцэтгүүлсэн тохиолдолд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр заалтын дагуу байгууллага бүрэн хариуцна.

9.2 Журамд заагдсан үүрэг, хариуцлагыг хангалтгүй биелүүлсэн тохиолдолд тухайн албан хаагчид энэхүү журам болон Төвийн хэмжээнд мөрдөгдөж байгаа бусад холбогдох дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.3 Журмыг дагаж мөрдөөгүйгээс үүдэн гарах хохирлыг тухайн албан хаагч өөрөө бүрэн хариуцна.

9.4 Энэхүү журмыг зөрчсөнөөс байгууллагын эд хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд эд хөрөнгийн бүрэн хариуцлагыг тухайн албан хаагчид хүлээлгэнэ.